# “УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ” ОНӨТҮГ-ЫН
# 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

## “УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ” ОНӨТҮГ-ЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1.** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ**. /НЗДҮАХ 2.4/** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1.** Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.. /НЗДҮАХ-2.4.3/ | | | | | | |
| 1.1 | Улаанбаатар хотын музейн үзүүллэгийн танхим болон ариун цэврийн өрөөний дотор засал, тохижилт ба гадна бохирын шугамын засварын ажлын төслийг батлуулж, хийж гүйцэтгэнэ. (Бүтээн байгуулалтын жил болгон зарласан ажлын хүрээнд) | 130,681,399 Нийслэлийн төсөв | Зураг төслийн дагуу ажил хийгдсэн байна | - | 100 | Ажлын гүйцэтгэл:<br>✓ Хот төлөвлөлт, судалгааны институт”-тай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдар ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж зураг төслийн ажил бүрэн хийгдэж дууссан.<br>✓ Дээрх зураг төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Яам, Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 34/2025 дугаар барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт гарч магадлан бүрэн хийгдсэн.<br>✓ Уг төслийг хэрэгжүүлэх 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/256 дугаар захирамж гарч Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025.03.24 өдөр НХААГ/20250101603 дугаартай тендер зарлаж Гурвангис ХХК шалгарсан.<br>✓ 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 08 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зураг төслийн дагуу хийж гүйцэтгэн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр комисс хянан шалгаж 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр “Ажил хүлээлцэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | акт" №01 үйлдэн засварын ажлыг бүрэн дуусган хүлээн авсан. (Хавсралт зураг 1-12)<br>✓ Гурван гис ХХК нь музейн барилга засварын ажлын чанарын баталгааг 4 жилийн хугацаатай гаргав. (2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/125 дугаар албан бичиг)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | | | | | | | |
| 2.1 | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлнэ. | 891,809.4 Нийслэлийн төсөв | Тайлан гаргаж хүргүүлсэн тоо | 2 | 2 | Нийт орлого: 890,259.4 мянган төгрөг Үүнд:<br>-төсвөөс 886,164.4 мянган төгрөг,<br>-өөрийн орлого 4,095.0 мянган төгрөг<br>Гүйцэтгэл: 759,373.2 мянган төгрөг<br>Үүнд:<br>-төсвөөс авсан санхүүжилт 756,126.2 мянган төгрөг<br>-үндсэн үйл ажиллагааны орлого 3,163.0 мянган төгрөг<br>-туслах үйл ажиллагааны орлого 84.0 мянган төгрөг<br>Нийт зардал:<br>-төлөвлөгөө 759,373.2 мянган төгрөг<br>-гүйцэтгэл 698,461.3 мянган төгрөг<br>2025 оны 12 сарын 03-ны байдлаар зардлыг задалбал:<br>1. Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардалд -546,378.7 мянган төгрөг<br>2. НДШ /АО/ -68,775.8 мянган төгрөг<br>3. Байр ашиглалтын тогтмол зардал -7,933.0 мянган төгрөг<br>4. Хангамж, бараа материалын зардал -10,884.6 мянган төгрөг<br>5. Хөдөлмөр хамгаалалын зардал-462.0 мянган төгрөг<br>6. Урсгал засвар -18,355.8 мянган төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТөлбөр, хураамж- 6,001.1 мянган төгрөг<br>8. Бараа үйлчилгээний бусад зардал- 3,923.1 мянган төгрөг<br>9. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал -3,950.8 мянган төгрөг<br>10. ЭША-725.0 мянган төгрөг<br>11. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламж-21,607.4 мянган төгрөг<br>12. Нэг удаагийн буцалтгүй тусламж- 2,900.0 мянган төгрөг<br>13. Түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах зардал-6,564.0 мянган төгрөг зарцуулсан.<br>-2025 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг боловсруулж гарган баталгаажуулан, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор хянуулан, хүргэж өгч нэгтгүүлсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.2 | Байгууллагын эд хөрөнгө болон тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, эд хариуцагчийн бүртгэл, карт хөтлөнө. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | **Байгууллагын эд хөрөнгө болон тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, эд хариуцагчийн бүртгэл, картыг бүрэн хөтөлсөн.**<br>-2025 оны жилийн эцсийн (2025 оны 12 дугаар 01 байдлаар) байдлаар байгууллагын эргэлтийн хөрөнгийн дансанд 9,487.0 мянган төгрөгийн бараа материалуудыг шинээр худалдан авч бүртгэн 21,002.66 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг анхан шатны баримт материалуудыг үндэслэн зарлагдсан. Ингэхдээ эд хөрөнгө тус бүрийг шалган хүлээн авч, няравын программд цаг тухай бүрт нь бүртгэл хөтөлж, зардлын ангиллын дагуу үнэн зөв тусгасан. Үндсэн болон бараа материалын тайланг улирал бүр гаргаж, сар болгоны 15-ны дотор хийж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэн нягтлан бодогчтой тооцоо нийлэн хянуулан баталгаажуулсан. (https://fiscus.stg.mn/InventoryBalance/Index2)<br>-2025 онд шинээр ажилд орсон үзмэр харгалзагч, хүүхдээ асрах чөлөөтэй байсан боловсролын ажилтан, үйлчлэгч нарын эд хөрөнгийн хариуцлагын гэрээг 2 хувь үйлдэж, эд хөрөнгийн хүлээлгэн өгч ашиглалтын картыг нь хөтөлсөн. Шинээр худалдан авсан хөрөнгийг эд хариуцагч бүрийн картанд цаг тухай бүрт нь бүртгэлийг хөтөлж, баталгаажуулсан. (Desktop;Ашиглалтын карт;2025;Ашиглалтын карт 2025.06 124KB)<br>-Төрийн өмчийн тооллогын программд байгууллагын 2025 оны өмчийн хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэж оруулсан. Үндсэн хөрөнгийн орлогод 15 нэр төрлийн нийт 96,775.50 мянган төгрөгийн эд хөрөнгүүдийг өмчийн программд хөрөнгийн ангиллын дагуу бүртгэсэн. Барилга байгууламж, Машин тоног төхөөрөмж болон компьютер түүний дагалдах хэрэгсэл, Тавилга эд хогшил, Түүх соёлын дурсгалт зүйлүүдийн фото зургийг авч, хөрөнгө тус бүр дээр зургийг хавсралтаар оруулсан. (Төрийн өмчийн тооллогын программд байгууллагын 2025 оны өмчийн хөрөнгийн хөдөлгөөний орлогыг шивж оруулсан. https://pcsp.gov.mn/)<br>-Музейн ажилтан албан хаагчдад шаардлагатай бичгийн цаас болон бусад материалд өссөн дүнгээр 2,169 ширхэг 3,132.73 төгрөг, цэвэрлэгээний болон аж ахуйн материал 890 ширхэг 6,943,158 төгрөг, сэлбэг хэрэгсэл 5 ширхэг 1,149,9 төгрөг, түлш шатах тослох материал нийт 2,150.00 төгрөг, барилгын засварын материал 385.50 ширхэг 3,581.25 төгрөг, хангамжийн материалын данснаас 3000 ширхэг 2.880.0 төгрөг, бусад материалын данснаас 622 ширхэг 39,769.50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг, нийт 59,606.58 төгрөгийн үнийн дүнтэй бараа материалыг цаг тухай бүрт нь анхан шатны баримтын дагуу олгож, бүртгэлийг хөтөлсөн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.3 | Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шаардлагатай үед хуралдуулах, байгууллагын эд хөрөнгийн хагас болон жилийн эцсийн тооллого хийж, үр дүн тус бүрийг Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлж ажиллах. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 4 удаа хуралдаж хурлын үр дүнг Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлсэн байна. Улаанбаатар хотын музейн “Өмч хамгаалах байнгын зөвлөл нь дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр музейн захирлаар батлуулав.<br>-2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 01 дүгээр хурал хуралдаж засварын ажлын үр дүнд бий болсон орлогыг барилга байгууламжийн дансанд 62,340,058 төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэх тухай мөн ашиглах жилийг 42 жилээр сунгах тухай хэлэлцэж Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн хурлаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж 01 хурлын дүгнэлт гаргав.<br>-2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 02 дугаар хурал хуралдаж музейн захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан 1,000,000 (нэг сая) төгрөгийн үнэ бүхий 9 дэсийн 39 ширхэг үзмэрийг эргэлтийн бус хөрөнгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн дансанд орлого авч бүртгэх 02 дугаар дүгнэлт гаргав.<br>-2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 03 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурал хуралдаж Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн 05 хурлаар хэлэлцүүлэн танилцуулж 03 дугаар дүгнэлт гаргав.<br>-2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 04 дүгээр хурал хуралдаж Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15,952,500 төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг суурин компьютер, 1 ширхэг олон үйлдэлт принтерийг үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөнийг орлого авах тухай хэлэлцэн Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэв.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2.4 | Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтыг хууль тогтоомж, стандарт, журам зааврын дагуу хөтлөн явуулна**.** | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | -Нийслэлийн Архивын газрын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/773 дугаар албан бичгээр ирсэн улсын үзлэгийн хуваарийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 13-ны өдрүүдэд 2020-2024 оны архив, албан хэрэг хөтлөлтөд улсын үзлэг шалгалт хийгдсэн. Улсын үзлэг шалгалтаар төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт зэрэг 3 үзүүлэлтээр дүгнэж комиссын урьдчилсан танилцуулгаар 85 оноогоор дүгнэгдсэн.<br>2025 оны архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, стандарт, журам зааврын дагуу хөтлөн явуулж 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар гүйцэтгэлийн хувь 95 байна.<br>Байгууллагад дараах үйл ажиллагааны бүртгэлүүдийг хөтөлж байна.<br>1.А,Б тушаалын бүртгэл<br>1.Цахим хэвлэл, мэдээллийн бүртгэл. Тайлант хугацаанд 31 мэдээ, мэдээлэл олон нийтэд хүргэсэн. 5201 үзэгчдийн хандалт авсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Цаасаар ирсэн бичгийн бүртгэл- 7 бичиг бүртгэсэн.<br>3. Ирсэн бичгийн бүртгэл- 207 бичиг<br>4. Явсан бичгийн бүртгэл -149 бичиг<br>5.Үзэсгэлэнгийн бүртгэл -1<br>6.Тогтоол шийдвэрийн бүртгэл- цахимаар ирсэн 18 хууль, тогтоол, захирамж-1<br>7.Хурлын тэмдэглэлийн бүртгэл 1<br>8.Архивын баримтын ашиглалтын бүртгэл-1<br>9.Хэвлэмэл хуудасны зарцуулалтын бүртгэл 1<br>10.Байгууллагын архивын байнга, түр, 70 жил, цахим гэрэл зургуудын хадгаламжийн нэгжийн бүртгэл-4<br>11. Өргөдөл, гомдлын бүртгэл-1<br>12.Илтгэх хуудас<br>13. Удирдамж<br>-Өссөн дүнгээр байгууллагад ирсэн бичиг нийт 207 байна. Судалж байгаа 3 албан бичиг. Хугацаа хоцорсон, шийдвэрлэгдээгүй бичиг байхгүй. Нийслэлийн Засаг даргын тамгын газар 2, Соёлын өвийн үндэсний төвөөс 1, нийт 2 бичиг байгууллагын хаяг андуурч ирсэн тул буцаасан.<br>-Өссөн дүнгээр байгууллагаас нийт 197 албан бичиг явуулсан байна. Явсан бичгийн стандарт, боловсруулалтад хяналт тавьж, хос бичгээр хэвлэмэл хуудсанд болон буулгаж, бүртгэж илгээж байна. Буцсан, зөрчилтэй бичиг байхгүй байна.<br>Байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлыг 2 удаа хийсэн. Үүнд:<br>-01 дүгээр хурлаар ХХНЖ, Данс бүртгэл, байгууллагын архивд 2024 оны баримт өгөх хадгаламжийн нэгжийн тухай<br>-02 дугаар хурлаар байгууллагын архивд тооллого хийсэн тухай тус тус хэлэлцэв.<br>-2025 онд хөтлөгдөх Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр шинэчлэгдсэн журмын дагуу боловсруулан батлуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2025 оны 3 сард 8 албан хаагчдаас хуваарийн дагуу 74 ш баримтуудыг хүлээн авч бүртгэл үйлдсэн.<br>- Архивын стандартын дагуу үдэж хавтасласан 2024 оны 74 ширхэг зөв бүрдэлтэй баримтуудыг байнга хадгалах, түр хадгалах, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж үүсгэн тус бүр бүртгэл үйлдэн, БНШК-оор хэлэлцүүлж, захирлаар батлуулсан. Үүнд:<br>1.Байнга хадгалах хадгаламжын нэгж 27 ширхэг<br>2.Түр хадгалах хадгаламжийн нэгж 40 ширхэг<br>3.70 жил хадгалах хадгаламжийн нэг 6 ширхэг<br>4.Цахим гэрлийн зургийн 1 хадгаламжийн нэгжийн 121 ширхэг гэрэл зураг<br>Нийслэлийн архивын газраас ирүүлсэн зөлөмжийн дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэгт бэлтгэх комисс байгуулан, төлөвлөгөө гарган ажилласан. Захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс 2025 оны 05 дугаар сарын 27-оос 5 дугаар сарын 30-ны өдрүүдэд архивын баримтад тооллого хийх ажлыг зохион байгуулсан.<br>Байгууллагын архивын 2002 оноос 2025 оны баримтуудад тооллого хийж<br>• Байнга хадгалах 2022-2024 оны 88 хадгаламжийн нэгж<br>• Түр хадгалах 2010-2024 оны 288 хадгалах нэгж<br>• 70 жил хадгалах 2002-2024 оны 101 хадгаламжийн нэгж<br>Нийт 513 цаасан суурьтай баримт тоолсон. Тооллогын комисс нь 2025 оны 06 дугаар сарын 13-н өдрийн Илтгэх хуудас, баримтын тооллогын хуудас, баримтын тооллогын акт, олдоогүй баримтын акт үйлдэн 2025 оны 07 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 09-ны өдрийн 92 дугаар албан бичгээр дээрх баримтуудыг илгээсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 90% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2.5 | “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвшүүлнэ. | - | Стандартын хэрэгжилтийг хангасан байна. | - | 100 | Албан хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр хөтлөх зааврын дагуу Нийслэлийн архивын газарт хэвлэмэл хуудасны захиалга өгч, хянуулан, хэвлүүлсэн.<br>-Захирамжлалын баримт болох А тушаал 43, Монгол бичгээр үйлдсэн хувь 43, Б тушаал 35, Монгол бичгээр үйлдсэн хувь 35-ийг хавсралтын хамт бүрдүүлж, үнэн зөв албан ёсны хүчинтэй байдлыг хангаж, хянуулан баримтжуулав. *Цахим файл: E:\2025 on\tushaal -256 fail, 7 folder, 167 MB*<br>-2025 оны 01 дүгээр сард Монгол бичгийн хэвлэмэл хуудас тушаал -300 ширхэг, албан бичгийн А4-300 ширхэг, А5-300 ширхэгийг Нийслэлийн архивын газарт захиалан хэвлүүлж, хүлээн авсан. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолыг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Хэвлэмэл хуудасны индекс батлах тухай” А/41 дүгээр тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл хуудсыг нэр төрлөөр нь индексжүүлэн шинэчлэн баталсан.<br>*Цахим баримт: Erp системийн e-Doc дахь архив дэд системд*<br>Монгол бичгээр хөрвүүлэх “Кимо” программыг худалдан авч албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба программын алдаанаас шалтгаалан зарим албан бичгийг хөрвүүлэн илгээж чадаагүй.<br>Хос бичгийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 52 дугаар албан бичгээр 1 дүгээр улирлын, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 121 дугаар албан бичгээр 3 дугаар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улирлын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт илгээсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 90% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2.6 | Дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн байгууллагад холбогдох заалтыг хяналтад авч, бүртгэл хяналтын карт хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн мэдээ тайланг хагас жил, бүтэн жилээр гаргаж, үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулж холбогдох дээд байгууллагад илгээнэ. | - | Илгээсэн тайлангийн тоо | 2 | 2 | Цахимаар ирсэн хууль, тогтоомж, захирамжлалын бүртгэл хөтөлсөн. Үүнд:<br>1.Шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж холбогдох тайланг сар бүр шилэн дансанд байршуулан ажиллаж байна. Үүнд:Нийт мэдээлэх 64, хугацаандаа мэдээлсэн 63, хугацаа хоцорсон мэдээлэл 1 байна. *shilendans@mof.gov.mn*<br>2. Shilen.gov.mn системд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 мэдээлэл байршуулсан байна. *Shilen.gov.mn*<br>3. Авлигын эсрэг хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг заасан хугацаанд холбогдох албан тушаалтнууд мэдүүлгээ гаргаж, илгээсэн.<br>4. 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолоор Музейн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар албан хаагчдын цалинг шинэчлэн баталсан.<br>5. МУ-ын Засгийн газрын тогтоол 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай” 109 дүгээр тогтоолоор Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сарын баярын өдрүүдийн мягмар, лхагва гарагуудад албан хаагчдыг амрааж, 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/10 дугаар тушаалаар нөхөн ажиллуулах зохицуулалтыг хийв.<br>6. Улсын их хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2025 оны 04 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тогтоолоор "Төрийн албан хаагчийн дижитал ёс зүй" сэдэвт сургалт нөлөөллийн ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 11-нд зохион байгуулав.<br>7. 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар "Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолоор Иргэн хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний төлбөр хураамжийг нэмэгдүүлэхгүй байх тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллав.<br>8. Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 147 дугаар "Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ асрах эцэг, эхэд ажлын тав хоногийн цалинтай чөлөө олгохоор шийдвэрлэсэн.<br>9.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга бат, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар албан даалгавар,"Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар, "Төрийн албаны сахилга бат, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 102, 103, 104 дүгээр албан бичгээр, 9 дүгээр сарын 22-ны өдрийн 111, 113, 114 дүгээр албан бичгээр, 10 дугаар сарын 27-ны өдрийн 133, 134, 135 дугаар албан бичгээр, 11 дүгээр сарын 24-ны өдрийн 147 дугаар албан бичгээр албан даалгаврын хэрэгжилтийг илгээсэн.<br>10. 2025 оныг "Тохижилт бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжаар Музейн үзмэрийн шилэн хоргыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр хийхэд зориулж, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах зардлаас 3.5 сая төгрөгийн зардал гаргаж хийлгэсэн.<br>11.“Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33, А/1541 дугаар захирамжаар 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд БЗД-ийн 9-р хороонд 14 албан хаагчид пийшин, зуухны хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч эх үүсвэр түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийв.<br>12. “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” А/62 дугаар захирамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Ажлын хариуцлагыг өндөржүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах” талаар албан хаагчдад үүрэг өгөв.<br>13. “Албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Б/05 дугаар захирамжаар Музейн захирал П.Даваасүрэнгийн албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоов.<br>14.“Нийслэлийн ерөнхий архитекторын зөвлөл байгуулах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/549 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн ерөнхий архитекторын зөвлөлийн бүрэлдэхүүнд музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр сонгогдон ажиллаж байна.<br>15. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай” А/905 дугаар захирамжийн дагуу Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр “Хангалттай” үнэлэгдсэн тул байгууллагын удирдлагад холбогдох журамд заасны дагуу урамшууллыг цалингийн санд багтаан олгосон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 16.Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн “Барилгын хог хаягдлыг дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх тухай” А/1101 дүгээр захирамжийн дагуу Засвар, тохижилтын ажил хийгдвэл захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар шийдвэрлэв.<br>17. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” А/789 дүгээр захирамжийн дагуу Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд “Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх журам”-ын дагуу гэрээ байгуулан ажиллахаар шийдвэрлэв.<br>18. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дүгээр захирамжийн дагуу Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг хуваарийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 13, 14-ны өдрүүдэд тус музейд явагдсан.<br>-Тайланг хугацаанд нь илгээж ажиллав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.7 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | 2025 оны хувьд тухайн үйл ажиллагааны хүрээнд эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, холбогдох бодлогын баримт бичиг хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна. 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд дараахь байдлаар тусгасан. Үүнд:<br>**Стратеги зорилго 4-т**<br>Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.<br>Зорилт .1<br>Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна.<br>Зорилт .2<br>Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ. | 100 |
| 2.8 | MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | | | - | 100 | | 100 |
| 2.9 | Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон | | | - | 100 | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | | | | | Зорилт.3<br>Оролцогч талуудын оролцоог хангана.<br>Зорилт.4<br>Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.<br>Зорилт.5<br>Гүйцэтгэл ба өөрчлөлтийг удирдлагыг сайжруулна.<br>Зорилт.6<br>Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлнэ.<br>Зорилт.7<br>Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл 7 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.10 | Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Тайлангийн тоо | 4 | 4 | I-IV улирлын Төрийн албан хаагчийн 2024 оны тоо бүртгэлийн тайланг “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн статистикийн албан ёсны мэдээний 9 маягт”-ын дагуу бөглөн Нийслэлийн Соёл, Урлагийн газарт цахимаар илгээв.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 2.11 | Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Батлуулсан бичиг баримтын тоо | - | 1 | Улаанбаатар хотын музейн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр батлуулав.<br>-Монгол Улсын Үндсэн хууль болон Соёл, музейн салбарт шууд хамаарах 7 хууль, төрийн алба, төсөв санхүү зэрэгт хамаарах 20 буюу нийт 27 хуулийн хүрээнд тодорхойлж Улаанбаатар хотын музейн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг 4 зорилго 8 зорилт, 31 арга хэмжээг дүрмээр хүлээсэн болон хуулиар олгосон гэсэн 2 чиг үүрэгт ангилан хэрэгжүүлэхээр боловсруулав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.12 | Музейн ажилтнуудын ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Үнэлгээний баг нь Улаанбаатар хотын музейн ажилтан, албан хаагчдыг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” хавсралт маягтуудын дагуу 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ажилтан тус бүрийн 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг үндэслэн ажилтан тус бүртэй тусгайлан ярилцлага, тайлангийн дэлгэрэнгүй тайлбар авч дүгнэн 2025 оны 06 дугаар сарын 20 өдөр гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллэх хуудсыг ил тод байршуулав.<br>-Шинээр ажилд орсон үзмэр харгалзагч Н.Ичинхорлоо, Б.Мөнгөнтуул нарын 3 сарын хугацаанд хийсэн ажлын тайланг дүгнэн Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 2.13 | Байгууллагын хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж, үр дүнг Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн хуралд танилцуулна. | - | Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 2 | 2 | -Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг НЗДТГ-т хүргүүлж батлуулан музейн захирал хариуцлагын гэрээ байгуулсан.<br>-Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн тайлан нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв.<br>-Музейн 2025 оны үйл ажиллагааны статистик мэдээ, 1,2,3-р улирлын үйл ажиллагааны статистик дүн мэдээг тус тус нэгтгэн НСУГ-т ERP болон nsug.statistic@gmail.com хаягаар илгээсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Байгууллагын 2025 оны жилийн жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг НЗДТГ, НСУГ-т хугацаанд нь тус тус хүргүүлсэн.<br>-Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний танилцуулгыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар хурлаар танилцуулав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.14 | Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаа, байгууллагын бүтцийн нэгж бүрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөө гаргаж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна. | - | Дотоод хяналт шалгалт хийсэн тоо | 4 | 4 | 2025 онд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан музейн захирлаар 1 дүгээр сард батлуулан 4 ажлыг зохион байгууллаа: Үүнд:<br>**1.**Музейн захирлын баталсан “Эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгаа, шинжилгээний ажилд хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хяналт шалгалт хийлээ. Уг үзлэг шалгалтаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Музейн тухай хууль, Музейн стандарт, Улс, орон нутгийн музейн дүрэм, музейн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг мөрдлөг болгон биечлэн үзэж, асуулт асууж, тэмдэглэл хөтөлж, 4.6 буюу 95%-ийн үнэлгээ өгсөн.<br>**2.**Музейн захирлын баталсан “Боловсролын ажилтны хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хяналт шалгалт хийлээ. Уг шалгалтаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Музейн тухай хууль, Музейн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | стандарт, Улс, орон нутгийн музейн дүрэм Улаанбаатар хотын музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны “Журам батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллав.<br>Үзлэгийг комиссын гишүүд биечлэн үзэж танилцах, асуулт асуух, удирдамжид заасан хяналт хүснэгтэд 0-5 оноогоор үнэлгээ хийж, гар тэмдэглэл хөтлөн, хяналтын хуудсанд өгсөн дундаж оноо 4.97 буюу 99.4%-ийн үнэлгээтэй гарсан нь музейн боловсролын ажилтны хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд “хангалттай” түвшинд буйг илтгэж байна.<br>**3.**Музейн захирлын баталсан “Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх” удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийлээ. Уг үзлэг шалгалтаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (цаашид ХАБЭА гэх)-н тухай хуулийн 14.1, 14.2, 15.1, 26.2, 27.1, 27.2 дахь заалтууд, Улаанбаатар хотын музейн ХАБЭА-н хяналтын журмын 2.2, 2.4, 7.1.1.8, 7.1.1.9, 7.2.1.1, 7.2.1.2, 7.2.1.3, 7.2.1.4, 7.2.1.5, 7.2.1.7, 7.2.1.9, 7.2.1.10 дахь заалтууд, Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны “Журам батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө, Улаанбаатар хотын музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг комиссын гишүүд мөрдлөг болгон ажиллав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХАБЭА-н үзлэгийг комиссын гишүүд биечлэн үзэж танилцах, асуулт асуух, удирдамжид заасан хяналтын хэвлэмэл хүснэгтэд 0-5 оноогоор үнэлгээ хийж, гар тэмдэглэл хөтөлж ажиллав.<br>Хяналт шалгалтад комиссын гишүүдийн хяналтын хуудсанд өгсөн дундаж оноо 3.97 буюу 79.5%-ийн үнэлгээтэй гарсан нь музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил “Дунд” түвшинд буйг илтгэж байна. Энэ удаагийн үзлэгээр илэрсэн зөрчлийг музейн захирлын дэргэдэх захиргааны зөвлөлөөр хэлэлцэн холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг өгч ажиллав.<br>**4.**Музейн захирлын баталсан “Музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг хийх” удирдамжийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг, шалгалт хийх ажлыг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Музейн тухай хуулийн 10.4, 10.5, 11.2 дахь хэсэг, Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5634:2006 стандарт (цаашид музейн стандарт гэх) Монгол улсын стандартын 12.4.10, 12.5.4, 12.9, 12.10 дугаар зүйл, Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны “Журам батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллав. Үзлэгийг комиссын гишүүд 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр музейн захирлын баталсан "Музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг, шалгалт хийх удирдамжийг үндэслэн музейн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сан хөмрөгийн үзмэрийн хадгалалт, хамгаалалтын байдалтай биечлэн үзэж танилцан, асуумж асууж, музейн захирлаар батлуулсан холбогдох музейн хууль, стандартын хяналтын хүснэгтэд 0-5 оноогоор үнэлгээ хийж ажиллав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.15 | Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн болон монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, тайлагнана. | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж гүйцэтгэлийн хувь 100 хувь байлаа.<br>Дээд байгууллагаас зохион байгуулсан танхимын 10 нэр төрлийн сургалтад өссөн дүнгээр 53 албан хаагчдыг хамруулсан.<br>Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим системд 19 албан хаагчийн төрд ажилласан жилийн мэдээллийг нэг бүрчлэн шинэчлэв.<br>Үзмэр харгалзагчийн ажлын байрыг нээлттэй зарлаж, ярилцлагуудыг зохион байгуулж үзмэр харгалзагчийг туршилтын хугацаатай ажилд аван тайланг дүгнэн байнгын ажлын байранд томилон ажиллуулав.<br>-2 ажилтан, 1 ахмад настанд хууль журамд заасны дагуу баримт бичигт үндэслэн буцалтгүй тусламж 1,100,000 төгрөгийг олгов.<br>-Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан архив, бичиг хэргийн ажилтан Д.Гантулгыг Соёлын тэргүүний ажилтнаар, тайлбарлагч Л.Одмаа, боловсролын ажилтан Б.Даваасүрэн, жижүүр Д.Мөнхтөмөр нарыг Соёлын яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнуулав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 2.16 | Удирдах дээд байгууллага, музейн олон нийтийн зохион байгуулалттай арга хэмжээнд оролцоно. (нийтийн их | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 4 | 5 | - 2025 оны 01-р сарын 19-ны өдөр Нийслэлийн засаг даргын “Агаар бохирдуулагч эх үүсгэврийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэвэрлэгээ, спортын арга хэмжээ гэх мэт) “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина. | | | | | захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хяналт тавьж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.<br>- 2025 оны 02-р сарын 21-нд Монгол улсын засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61.1 дугаар зүйлийн 61.1.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2 Дүүргийн засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн дагуу “Хариуцлагатай, Халтиргаагүй, Хоггүй Шинэльe” уриан дор Улаанбаатар хотын музейн хашаанд болон ойр орчмын 50 метрт хог, хаягдал цэвэрлэлээ. Хог хаягдлыг шуудайд хийж музейн хогийн цэгт төвлөрүүлэхэд оролцож ажилласан.<br>-2025 оны 03-р сарын 28-ны өдөр Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-нд оролцож Нийслэлийн Засаг даргын А/354 дугаар захирамжийн дагуу музейн ажилтнууд Сөүлийн гудамжнаас Энхтайваны өргөн чөлөө хүртэл зам талбайг цэвэрлэв.<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ивээл дор зохион байгуулагдсан Улаанбаатар хотын циркийн өдрүүд" арга хэмжээнд 04-р сарын 18, 19-ны өдрүүдэд орох, гарах хаалган дээр зогсож зохион байгуулах ажилд оролцож ажилласан.<br>- Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарихад оролцож ажилласан.<br>-Соёл урлагийн ажилтны өдрийн баярын хурал, баярын нэгдсэн үйл ажиллагаанд оролцов.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 100 |
| 2.17 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | -2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар хотын музейн Ёс зүйн дэд хорооны ажиллах төлөвлөгөөг батлуулав.<br>-Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, санал хүсэлт, ёс зүйн шинжтэй зөрчлийн мэдээлэл музейн ёс зүйн дэд хороонд ирээгүй.<br>Хэрэгжүүлсэн ажлууд үүнд:<br>**Тайлан:**<br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх тайлан, ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээллийг маягтын дагуу тус тус боловсруулан НЗДТГ-т илгээв.<br>-Музейн ёс зүйн дэд хорооны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тайлагнав.<br>-2025 оны эхний хагас жилийн ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг www.ubmuseum.mn, www.shilen.gov.mn цахим хуудсанд ил тодоор тогтмол байршуулж байна.<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга бат, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг дээшлүүлэх” 01 дүгээр тогтоол, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, “Төрийн албаны сахилга бат, дэг журам, хариуцлагыг чангатгах” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг 2025 оны 08, 09, 10, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь илгээж ажиллав.<br>**Судалгаа:**<br>-Ёс зүйн тухай ойлголт, ёс зүйн тухай хууль, тогтоомж, хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг илрүүлэх зорилготой 16 албан хаагчдаас судалгааг авсан. Судалгаанд оролцогчдын 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь нь ёс зүйн тухай хууль, тогтоомж, хэм хэмжээг дагаж мөрддөг болохыг судалгаагаар илрүүлсэн. Цаашид ёс зүйн хандлагыг шудрага зарчимч байхад тулгуурласан ёс зүйн төлөвшил, хөгжлийн хандлагатай хослуулан хэрэглэх, олон талт сургалт сурталчилгааны арга хэмжээнүүдийг зохион байгуулах нь зүйтэй гэж дүгнэсэн.<br>**Сургалт:**<br>-2025 оны 2 дугаар сарын 18-нд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ-ын сургагч багш Ч.Ундрах музейд хүрэлцэн ирж, "Цахим орчин ба хүний эрх" сэдэвт 1 цагийн сургалтыг музейн танхимд зохион байгуууллаа. Сургалтад музейн бүх албан хаагчид хамрагдсан ба албан хаагчид<br>- Хүний эрхийн тухай ойлголт мэдээлэл<br>- Цахим орчин дахь хүний эрхийн зөрчил<br>тухай ойлголтын авч, сэдвийн хүрээнд асуулт асуух, харилцан санал солилцох зэргээр сургалт амжилттай явагдсан.<br>-2025 оны 09 дүгээр сарын 11-нд музейн арга зүйч "Төрийн албан хаагчийн дижитал ёс зүй" сэдэвт сургалт бэлтгэн музейн албан хаагчид бүгд хамрагдав.<br>-2025 оны 11 сарын 25-ны өдөр музейн байранд зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, холбогдох хууль журмын танилцуулга" сэдэвт сургалт<br>Музейн ёс зүйн дэд хорооны 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд сургалтад 600,000 мянган төгрөгний төсөв тусгагдсан ч төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу санхүүжилт олгогдоогүй төлбөртэй сургалтууд цуцлагдсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.18 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж арга хэмжээ зохион байгуулна. | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор дараах ажил хийгдсэн.** Үүнд:<br>-“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ-д Улаанбаатар хотын музейгээс сургалт зохион байгуулах санал тавьж, 2025 оны 2-р сарын 18-нд тус байгууллагын сургагч багш Ч.Ундрах хүрэлцэн ирж “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдвээр сургалт орсон.<br>-“Харилцан хүндэтгэе” 2025 оны нэг сарын аянд нэгдэж “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” логог ашиглан бичлэг бэлтгэж музейн мэдээллийн цахим сувгууд болох ERP сүлжээ, инстаграм мөн facebook хаягуудад тус тус байршуулан нийт 1,204 хүний хандалт авсан.<br>Холбогдох линк: https://www.facebook.com/share/v/19UeQZ4nLA/<br>https://www.instagram.com/reel/DG5MOW8SrF-/?igsh=MWtocHY1czZqNGVzdQ==<br>-Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэж “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье” сэдвээр постер бэлтгэн цахим хуудсуудад нийтэлж олон нийтийн хүртээл болгосон.<br>**Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:**<br>-Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчилах постерийг www.ubmuseum.mn www.ulaanbaatar.erp.mn<br>хуудсуудад тус тус нийтэлсэн(288 үзэлт) .<br>https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum хуудсанд Авлигын эсрэг хуулийг сурталчилах видео шторк нийтэлсэн.<br>-Авлигын эсрэг хуулийг сурталчилах видео шторк-1 Холбоос: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum/videos/724142486855878/ (315 үзэлт)<br>-Авлигын эсрэг хуулийг сурталчилах видео шторк-2 Холбоос: https://www.facebook.com/share/v/1MRijzXd6k/ (836 үзэлт)<br>-Авлигын эсрэг хуулийг сурталчилах видео шторк-3 Холбоос: https://www.facebook.com/share/v/17VemzZodh/ (416 үзэлт) нийт 1855 үзэлт, хандалт авсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.19 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах журмын хэрэгжилт, чиг үүргийг хангаж ажиллана. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | - | 2 | **1.Музейн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлуулж дараах ажлыг хийв.**<br>-“Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд Музейн “Галын аюулгүй байдлын дүгнэлт”-ийг 2 жилийн хугацаатай гаргуулсан.<br>-Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2022 оны А/120 дугаар тушаалаар батлагдсан “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, Улаанбаатар хотын музейн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/39 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын музейн “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх” ажлыг зохион байгуулж үр дүнг удирдлагад танилцуулав.<br>-Музейн барилгын засварын ажлын аюулгүй байдлын зааварчилгаа боловсруулж ажилтнуудад заавар өгсөн. (хавсралт-1)<br>-Музейн барилгын засварыг гүйцэтгэж буй Гурвангис ххк-д барилгын засварын ажлын байрны аюулгүй байдлыг хангах талаар албан бичиг явуулж, аюулгүй байдлыг хангах талаар тодорхой ажлууд хийгдсэн. (хавсралт-2)<br>-Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл худалдан авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Цахилгаан багажны бэлэн байдал, зөөврийн шат. Цахилгаан тоног төхөөрөмжүүдэд үзлэг хийхэд бүрэн бүтэн, хэвийн ажиллаж байсан.<br>-Галын аюулгүй байдлын самбар 1 ширхэг, ослын гарцын заах тэмдэг 3 ширхэгийг худалдан авсан.<br>**-Музейн 2025 оны мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.**<br>**-**Вирусны эсрэг программ худалдан авч 5 ажилтны компьютерт суулгасан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2.20 | Мэргэжлийн чиг үүргийн хүрээнд дээд байгууллага болон музейн захиргаанаас баталсан зөвлөл, комисс тухай хуралдаж асуудлыг шийдвэрлэнэ. (Арга зүйн зөвлөл, Сан хөмрөгийн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл гэх мэт) | - | Зохион байгуулсан хурлын тоо | 4 | 4 | **1.**Музейн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 16 ны өдрийн А/03 тушаалаар музейн сан хөмрөгийн байнгын зөвлөлийг шинэчлэн батлуулж үзмэрийн баяжилт хийх тухай 1 удаа хуралдсан.<br>**2.**Музейн хамт олны зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж музейн албан хаагчдаас дээд байгууллагын шагналд тодорхойлох тухай хэлэлцэв.<br>**3.**Арга зүйн зөвлөл 2 удаа хуралдан 5 дэсийн 39 ширхэг үзмэр музейн сан хөмрөгт бүртгэн авахаар тогтсон мөн “Улаанбаатар хотын иргэдийн аман түүх” хөтөлбөр хэлэлцэн музейн захирлын А/37 дугаар тушаалаар батлуулав.<br>**4.**Музейн эцэг эхийн зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг гарган дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-Музейн ажилтан албан хаагчдын 16 хүүхдэд “Гэр бүл эерэг орчин” боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан. (Зураг 1)<br>-Бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гаргах, эцэг эхийн хуралд суух цагийг байгууллагын зүгээс зохицуулж шийдвэрлүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Музейн ойр орчмын 500 метрт байрлах хүүхэд унаж бэртэж болохуйц нүх, траншейны тагийг бөглөх, засах, ил задгай цахилгааны утсыг далдлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. (Зураг 2)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| **Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт –** Музейн зорилго, үйл ажиллагааны чиглэл /НИТХ Тэргүүлэгчдийн тогтоол дугаар 32/ | | | | | | | |
| 3.1 | **Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулна. /УБХМД-4.2.1/** | | | | | | |
| 3.1.1 | Байгууллага, иргэдийн гар дээр байгаа үзмэр, эд өлгийн зүйлийн хайгуул, судалгаа хийж, сан хөмрөгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сан хөмрөгийг баяжуулах ажлыг зохион байгуулна. | - | Баяжуулсан үзмэрийн тоо | 5 | 5 | Тайлант хугацаанд Музейн захирлын 2025 оны А/23 дугаар тушаалаар музейн сан хөмрөгийг 9 дэсийн 39 ширхэг үзмэрээр баяжилт хийв. Нийт өссөн дүнгээр **825 дэсийн 3546 үзмэр эд өлгийн зүйл** музейн сан хөмрөгт хадгалагдаж байна.<br>-1959, 1970, 1981, 2001, 2004 онд хамаарах нийт 17 ширхэг зоос;<br>-18 ширхэг бичиг баримтын төрлийн эд өлгийн зүйл;<br>-Ялалтын баярын 80 жилийн ойд зориулан гаргасан 1 ширхэг хэлхээ марк;<br>-Улаанбаатар хотын усны барилга байгууламжийн схем зураг 1 ширхэг, Нийслэл Улаанбаатар хотын 385 жилийн ойд зориулан гаргасан 2 ширхэг хэлхээ маркаар тус тус музейд бэлэг, хандиваар баяжилт хийсэн.<br>-Музейн захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/23 дугаар тушаалаар 1,000,000 (нэг сая) төгрөгийн үнэ бүхий 9 дэсийн 39 ширхэг үзмэрийг эргэлтийн бус хөрөнгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн дансанд орлого авч бүртгэн баримтжуулсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | Улаанбаатар хотын түүх судлалын баримт, мэдээллийн санг баяжуулах ажлыг зохион байгуулна. | - | Баяжуулсан баримтын тоо | - | 4 | 2022 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын хээрийн судалгааны бүртгэл маягтын дагуу Улаанбаатар хотын 9 дүүргийн түүх, соёлын 143 үл хөдлөх дурсгалын анхан шатны гараар хөтөлсөн бүртгэл маягтыг Улаанбаатар хотын түүхийн судалгааны баримт, мэдээллийн санд хүлээлгэн өгч, баяжуулах ажлыг зохион байгуулав. (Хавсралт зураг №)<br>Музейн бүртгэл мэдээллийн санд бүртгэн авав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.1.3 | Нийслэлийн дурсамжийн санг баяжуулах ажлыг зохион байгуулна. | - | Баяжуулсан баримтын тоо | 4 | 4 | 2025.06.06-нд иргэн Д.Батжаргал (88002512), 2025.06.09-нд М.Батмөнх (91195419) нараас аман түүхийг дүрс бичлэгээр баталгаажуулан авч, гавьяат тээвэрчин Б.Ганбатын 2016 онд бичсэн “Улаанбаатарын тухай дурсамж”, сэтгүүлч Г.Баатарчулууны 2011 онд бичсэн “Миний анх үзсэн Улаанбаатар” дурсамжийг олж авч, нийслэлийн дурсамжийн санг 4 хүний дурсамж, аман түүхээр баяжуулав. Дүрс бичлэг, дурсамжийг музейн бүртгэл мэдээллийн санд хүлээлгэн өгсөн. (Хавсралт файл GB)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.2 | **Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын баталгаат орчин бүрдүүлж, үзмэрийг арчлан тордон, сэргээн засварлуулна**. **/УБХМД-4.2.2/** | | | | | | |
| 3.2.1 | Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын харьцуулсан судалгаа хийж, батлагдсан төсөвт багтаан бараа материал, тоног төхөөрөмжийг захиалгаар хийлгэх, худалдан авна. | - | Бараа материал, тоног төхөөрөмжийн тоо | 3 | 4 | 2025 онд соёлын биет өвийг хамгаалж эрсдэлээс сэргийлэх ажилд нийт батлагдсан төсөв 9,329,000 төгрөг үүнээс 6,979,100 төгрөгийг зарцуулж доорх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Музейд шинэ шилэн хорго 3,500,000 төгрөг, шилэн хоргоны гэрэлтүүлэг 495,000 төгрөөр хийж гүйцэтгэв. (зураг 6)<br>2.Үзмэр зөөж тээвэрлэх зориулалттай тавцант тэрэг 350,000 төгрөгөөр худалдан авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.Музейн үзмэр хадгалж хамгаалах, зөөж тээвэрлэх үзмэр ороох зориулалттай ямбуу даавуу 149,600 төгрөгөөр худалдан авсан.<br>4.Стандарт, хэмжил зүйн газраар 3 электрон жинг 210,000 төгрөгөөр баталгаажуулсан.<br>5.Цаг уур орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид чийг, дулаан хэмжигч 2 багжийг 54,000 төгрөгөөр баталгаажуулсан.<br>6.”Алтан бийр” ХХК гэрээ байгуулж UBM.61.5 хувийн дугаартай “Гэрэл тавигчид” уран зураг, UBM.61.69 хувийн дугаартай “Тэнгэрийн багана” уран зураг, нийт 2 ширхэг уран зурагт 1,500,000 төгрөгөөр жааз хийлгэсэн. (зураг 7)<br>-Музейн үзмэрийг хадгалалтад шаардлагатай 4 тоног төхөөрөмж, бараа материал худалдан авч, сан хөмрөгийн улсын тооллогод бэлдэх ажлын хүрээнд жин хэмжүүр, чийг дулаан хэмжих багаж баталгаажуулсан мөн 3 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.2.2 | Музейн сан хөмрөгийн өрөө, үзүүллэгийн танхимын хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулна. | | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 2 | 2 | Тайлан хугацаанд музейн сан хөмрөгийн өрөө, үзүүллэгийн танхимын хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулах 4 ажил зохион байгуулсан.Үүнд:<br>**Үзүүллэгийн танхимд:**<br>-1 болон 2 дугаар танхимд байрлах 4 шилэн хоргоны дэглэлтийг шинэчлэн шилэн хоргонд үзмэр байрлуулахад зориулалттай 12 ширхэг тавиур шинээр хийсэн. Шилэн хоргонд нийт 24 дэсийн 35 ширхэг үзмэр байрлуулсан. (зураг 8)<br>-2025 оны 04 дүгээр сарын 21 ны өдрийн музейн захирлын А/16 дугаар тушаалаар 3,500,000 төгрөгөөр музейн үзүүллэгийн 1 р танхимын шашны эд зүйл хадгалах шилэн хоргыг шинээр хийлгэж 14 дэсийн 19 ширхэг үзмэрийг байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өссөн дүнгээр нийт 38 дэсийн 54 ширхэг үзмэрийн дэглэлтийг шинэчлэн хадгалалтын нөхцөлийг сайжруулсан.<br>**Сан хөмрөгт:**<br>-Сан хөмрөгт хадгалагдаж буй 81 дэсийн 173 ширхэг үзмэрийн шинж байдалд тохируулан хадгалалтын нөхцөлийг сайжруулсан. (зураг 10)<br>**-**Хувийн дугаар нь бүдгэрсэн шаардлага хангахгүй болсон үзмэр эд өлгийн зүйлийн жагсаалт шүүн гаргаж хувийн дугаарыг сэргээн тавьж 113 дэсийн 238 ширхэг үзмэрийн хувийн дугаарыг сэргээн тавьсан.(зураг 11)<br>-Музейн сан хөмрөгийн өрөөний гэрлийг сүүлийн 5 жил шинэчлээгүйгээс бүдгэрч харагдах орчин муудсаныг зориулалтын шинэ гэрэл тавьсан.<br>-Музейн сан хөмрөгийн өрөөний тавиур, шүүгээнд байршлын товьёг хийж үзмэрийг шинж байдлаар нь ангилан төрөлжүүлсэн. (зураг 9)<br>Өссөн дүнгээр 194 дэсийн 411 ширхэг үзмэрийн хадгалалтын нөхцөл сайжруулах, хувийн дугаарыг сэргээн тавих ажил хийгдсэн байна.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.2.3 | Музейн ариутгал халдваргүйжүүлэлт, хортон шавжийн устгал хийлгэнэ. | - | Ариутгал хийсэн тоо | 2 | 2 | Тайлант хугацаанд нийт 3 удаа гэрээт байгууллага болох “ХанСудар” ХХК-аар хортон шавж халдваргүйжүүлэлтийг өссөн дүнгээр 720,500 төгрөгөөр хийж гүйцэтгүүлэв. (зураг 5) Үүнд:<br>1.Сан хөмрөгийн болон үзүүллэгийн танхимын үслэг болон даавуун эдлэлд хортон шавж үүсэх эрсдэл үүссэн тул урьдчилан сэргийлэх үүднээс хортон шавжийн устгал ариутгалыг 143,000 төгрөгөөр хийлгэсэн. 3 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2.Гэрээнд заасан хувиарын дагуу 5 болон 10 сард 2 удаа хортон шавж халдваргүйжүүлэлтийг музейн 250 м кв байранд 577,500 төгрөгөөр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.2.4 | Музейн барилга, сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдал болон музейн үйл ажиллагааны явцад хөтлөгдөх бүртгэлүүдийг тогтмол хөтөлж, хяналт тавина.(Гэрэл, чийг дулаан, цэвэрлэгээ, түлхүүр, орсон гарсан, лац) | - | Бүртгэл хөтөлсөн дэвтрийн тоо | 5 | 6 | Тайлант хугацаанд:<br>1.“Сан хөмрөгийн түлхүүр хүлээлцэх бүртгэл”, ”Сан хөмрөгт орсон гарсан бүртгэл”-ийг нийт 115 удаа тэмдэглэл хөтлөн улирал тутамд нэг удаа бүртгэл мэдээллийн санч хяналт тавин ажилсан.<br>2.”Сан хөмрөгт орсон гарсан хүний бүртгэл” 115 удаа тэмдэглэл хөтлөн улирал тутамд нэг удаа бүртгэл мэдээллийн санч хяналт тавин ажилсан.<br>3.”Сан хөмрөг, үзүүллэгийн танхимын чийг, дулаан хэмжих бүртгэл”<br>Нийт сан хөмрөгийн өрөөний чийг дулааныг 70 удаа хэмжилт хийж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.<br>Үзүүллэгийн танхимын чийг дулааныг 196 удаа хэмжиж шаардагатай арга хэмжээг авав.<br>4.”Сан хөмрөг, үзүүллэгийн танхим, үзмэрийн арчилгаа цэвэрлэгээ хийсэн бүртгэл”<br>Сан хөмрөгт нийт 31 удаа цэвэрлэгээ хийж, арга зүйч хянасан.<br>Үзүүллэгийн танхим дахь туслах хэрэглэгдэхүүний арчилгаа цэвэрлэгээг 106, үзмэрийн цэвэрлэгээг 14 удаа тус тус хийж бүртгэл хөтлөн арга зүйч хянан баталгаажуулав. Музейн 1-р танхимд хадгалагдаж буй UBM74.4 “БНМАУ мандтугай” , UBM84.15 “Энхийн Улаанбаатар”, UBM08.2 “Хангарьд”, UBM82.2 “Л.И.Брежнев”, UBM09.13 “Батола сүмийн загвар”ыг үзмэр харгалзагчтай хамтран цэвэрлэгээ хийсэн. (зураг 12) | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд өссөн дүнгээр нийт 55 дэсийн 102 ширхэг үзмэрийн цэвэрлэгээг хийсэн.<br>5.”Сан хөмрөг, үзүүллэгийн танхимын гэрэлтүүлгийн бүртгэл”<br>Нийт 12 удаа хийж журмын дагуу бүртгэн баримтжуулсан.<br>6.”Үзүүллэгийн танхимын түлхүүр болон витринд дэглэгдсэн үзмэрүүдийн лацны бүртгэл”<br>Ажлын 5 өдөр шалгаж тухайн өдрийн жижүүрт хүлээлгэн өгч нийт 106 удаа бүртгэл хөтөлж арга зүйч хянасан.<br>-Музейн сан хөмрөгийн өрөөний үзмэрийн байршлын зураг, бичлэгийг 1 болон 10 дугаар сард тус тус хийж баримтжуулан музейн бүртгэл мэдээллийн санчид хүлээлгэн өгсөн. (This PC-New Volume(F;)П.Ариунаа 2025 он-зураг-хадгалалт хамгаалалт-байршлын бичлэг) 101 MB<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.3 | **Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ. /УБХМД-4.2.3/** | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.3.1 | Музейд шинээр авсан үзмэрийг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтэрт бичилт хийж, Соёлын өвийн нэгдсэн бүртгэлийн программд бүртгэн оруулна. | - | Бүртгэгдсэн үзмэрийн тоо | 5 | 5 | Музейд шинээр авсан 9 дэсийн 39 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг үзмэрийг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтэрт бичилт хийж, нэг бүрчлэн үзмэрүүдийн зургийг аван баталгаажуулж, Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системд бүртгэн оруулав. https://ncch.cis.mn/auth/login<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2 | Бүртгэн баримтжуулах зааврын дагуу музейн сан хөмрөгөөс үзмэр, эд өлгийн зүйлийг гаргах, буцаах акт үйлдэн, хөдөлгөөнд оруулах ажлыг зохион байгуулна. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Соёлын Өвийн Үндэсний төвд сэргээн засварлуулахаар өгсөн 6 дэсийн 7 ширхэг үзмэрийг “Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах актийг үйлдэн баталгаажуулж, 2025 оны 03 сарын 13-ны өдөр хүлээн авч, үзмэрүүдээ зөөж тээвэрлэх журмын дагуу боож баглан, үзмэрийн боож баглахын өмнөх болон дараах явцын зураг авч, 94-00 дугаартай Prius 20 маркийн машинаар тээвэрлэн бүрэн бүтэн авчирч, музейн сан хөмрөгт оруулав. Хүлээн авсан үеийн зураг, бичлэгийг хийж, цахим файл үүсгэн компьютерт хадгалав.<br>Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/256 дугаар захирамжаар музейд урсгал засварын ажил 2025 оны 05 сарын 26-ны өдрөөс эхэлсэн. Батлагдсан зураг төслийн дагуу музейн үүдэнд налуу шат шинээр хийх болсон тул уг шатны хажууд байрлуулсан UBM61.56 хувийн дугаартай “Музейн барилгын тухай” цементен хавтан самбарыг зөөж, өөр газар байрлуулах ажлын хүрээнд Музейн захирлын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/26 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, 2025 оны 07 дугаар сарын 21-ны өдөр музейн UBM61.56 хувийн дугаартай “Музейн барилгын тухай” үзмэр болох цементэн хавтан самбарыг 3 метр орчим зайд кранаар аюулгүй байдлыг ханган өргөн зөөж, суурийн цутгалт хийж бат бөх хөдөлгөөнгүй байрлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. (Зураг4)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.3.3 | Музейн эрдэм шинжилгээний ажилтны бичсэн үзмэрийн тодорхойлолт, судалгааны ажил, монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийг хөрвүүлэг, орчуулгыг хүлээн авч, | - | Баяжилт хийсэн үзмэрийн тоо | 20 | 32 | Музейн захирлын 2025 оны 02-р сарын 10-ны А/08 тушаалаар батлуулсан. 2025 онд хөрвүүлэх, судлах үзмэрийн жагсаалтын дагуу эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэнгийн бичсэн үзмэрийн тодорхойлолт, үзмэрийн түүхийн судалгаа, алдаатай мэдээллүүдийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзмэрийн мэдээллийн баяжилтыг хийнэ. | | | | | зассан саналыг хүлээн авч, нийт **32 үзмэрийн** мэдээллийн баяжилтыг хийв. Үүнд:<br>-Үзмэрийн түүхийн судалгааг хийж, алдаатай мэдээллүүдийг зассан **20 үзмэр**<br>-Монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн **12 үзмэр**<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.4 | **Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүллэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно. /УБХМД-4.2.4/ /ХХИ-56-Соёлын хүртээмж/** | | | | | | |
| 3.4.1 | Сан хөмрөгийн үзмэрийн сэдэвчилсэн болон түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой үзэсгэлэн гаргаж олны хүртээл болгоно. | - | Үзэсгэлэнгийн тоо | 2 | 2 | Тайлант хугацаанд Улаанбаатар хотын музейгээс сан хөмрөгийн сэдэвчилсэн болон түүхэн тэмдэглэлт үйл явдлын 2 үзэсгэлэн зохион байгуулж, том хүн 270, оюутан 541, хүүхэд 751, гадаад хүн 29, нийт **1591** хүн үзэж сонирхсон. Үүнд:<br>-2025 оны 03-р сарын 10-нд Музейн нээлттэй өдрүүдийн арга хэмжээнд зориулан Норвегийн аялагч Оскар Мамены авсан гэрэл зургуудаар “XX зууны эхэн үеийн Монголчууд” гэрэл зургийн үзэсгэлэнг музейн танхимд дэглэж, олны хүртээл болгоход оролцож ажилласан.<br>-2025 оны 05-р сарын 07-нд Бүгд Найрамдах Буриад Улсын Төрийн архивтай хамтран “Ялалтын баярын 80 жилийн ой” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг музейн танхимд дэглэж, олны хүртээл болгосон.<br>2025 онд музей дээр түүхэн тэмдэглэлт үйл явдалтай холбоотой 2 үзэсгэлэнг дэглэж, олны хүртээл болгосон байна.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.4.2 | Түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой явуулын үзэсгэлэнг зохион байгуулна. | - | Үзэсгэлэнгийн тоо | 3 | 4 | Тайлант хугацаанд түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой явуулын нийт **11** үзэсгэлэн зохион байгуулсан байна.<br>1.2025 оны 2-р сарын 4-нд Багахангай дүүргийн Зорилтот жилийн арга хэмжээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулан “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэн<br>2.2025 оны 2-р сарын 6-нд Хобби сургууль дээр “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнг дэглэж, 500 хүүхдэд хотын түүхийн тухай лекц уншсан.<br>3.2025 оны 5-р сарын 11-12-нд Монгол-Унгар Улс дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Унгар Улсын Будапешт хотод зохион байгуулагдсан “Улаанбаатар хотын соёлын өдрүүд” арга хэмжээнд “Нүүдэлчдийн нийслэл хот” гэрэл зургийн үзэсгэлэн<br>4.2025 оны 5-р сарын 16-18-нд Олон улсын музейн өдрийг тохиолдуулан Улаанбаатар экспо 2025 арга хэмжээн дээр “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэн<br>5.2025 оны 5-р сарын 30-нд Скай ресортод зохион байгуулагдсан Wonderland kids festival арга хэмжээнд “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэн<br>6.2025 оны 06-р сарын 28, 29-ний өдрүүдэд Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр “Хүрээ цам-Даншиг наадам Хүй долоон худагт зохион байгуулагдаж Улаанбаатар хотын музейгээс “Богдын хүрээ ба Улаанбаатар” түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн мөн Нийслэл хотын түүхэн дурсгалт барилгуудын лего үзмэрүүд, Судлаач, уран бүтээлч Сугарын Чулуунбаатарын түүхэн судалгаанд тулгуурлан VIII Богд Жавзандамбын амьдралтай холбоотой онцгой цуглуулгуудыг тодоор сэргээн баринтагласан 12 ширхэг усан будгийн уран зургийн бүтээлүүдийн үзэсгэлэн<br>7.2025 оны 10-р сарын 13-15-ны өдрүүдэд БЗД-ийн ЕБ-ын 84-р сургууль дээр Японы гэрэл зурагчин Сүгияама Тэрүзогийн гэрэл зургуудаар “Миний Улаанбаатар” сэдэвт үзэсгэлэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8.2025 оны 10-р сарын 20-29-ны өдрүүдэд Улаанбаатар хотын нийтийн төв номын сан дээр Японы гэрэл зурагчин Сүгияама Тэрүзогийн гэрэл зургуудаар “Миний Улаанбаатар” сэдэвт үзэсгэлэн<br>9.2025 оны 10-р сарын 15-аас 11-р сарын 01-ны өдрүүдэд Хүүхдийн номын сан "Шилжилтийн үеийн Улаанбаатар (1985-2005)" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн<br>10.2025 оны 10-р сарын 23-ны өдөр ЕБ-ын “Шинэ үе” сургууль дээр Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгалын легогоор хийсэн бүтээлүүдийн үзэсгэлэнг<br>11..2025 оны 11-р сарын 18-19-ны өдрүүдэд “Дулааны IV Цахилгаан станц ТӨХК” дээр Японы гэрэл зурагчин Сүгияама Тэрүзогийн ховор нандин 40 гэрэл зургаар “Өнгөрсөн үеийн Улаанбаатар” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн (Зураг 2)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.4.3 | Музейгээр болон сэдэвчилсэн түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой үзэсгэлэн, явуулын үзэсгэлэнгээр үйлчлүүлсэн үзэгчдийн тоо мэдээг гаргаж судалгаа дүгнэлт хийнэ. | - | Үйлчлүүлэгч-дийн тоо | 3,000 | 5,000 | -Тайлант хугацаанд Улаанбаатар хотын музейгээс түүхэн тэмдэглэлт үйл явдал болон цаг үеийн холбогдолтой **13** үзэсгэлэн зохион байгуулж, 7141 том хүн, 5088 хүүхэд, 110 гадаад иргэн нийт **12,339** хүн үзэж сонирхон олны хүртээл болгосон байна.<br>-Дээрх тоон үзүүлэлтийг харахад нийт үйлчлүүлэгчдийн зөвхөн 20 хүртэл хувь нь музейгээр үйлчлүүлж 80-аас илүү хувь нь музейгээс гадуур зохион байгуулсан явуулын үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд хамрагдсан байна.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.5 | **Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна. /УБХМД-4.2.5/** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1 | Улаанбаатар хотын түүх судлалын баримт, мэдээллийн сангийн дүрмийг боловсруулан, үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Улаанбаатар хотын түүх судлалын баримт, мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд тус баримт, мэдээллийн сангийн дүрмийг эцэслэн боловсруулж, Арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. 12 дугаар сард багтаан музейн захирлын тушаалаар баримт, мэдээллийн сан байгуулах, дүрмийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 80% | 80 |
| 3.5.2 | Нийслэлийн иргэдийн дурсамжийг сурвалжлан авах, хадгалах зорилго бүхий “Улаанбаатарын аман түүх” хөтөлбөр боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулна. | - | Батлуулсан хөтөлбөрийн тоо | - | 1 | 2025.09.10-ны музейн арга зүйн зөвлөлийн 2025 оны 02 дугаар хурлаар “Улаанбаатар хотын иргэдийн аман түүх” хөтөлбөрийг хэлэлцүүлж, музейн захирлын 2025.09.29-ний өдрийн А/37 тушаалаар батлуулсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.5.3 | Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр судалгаа хийж, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлнэ. | - | Хэвлүүлсэн өгүүлэл, нийтлэлийн тоо | - | 2 | 1.Улаанбаатар хотын 385 жилийн ойд зориулсан “Улаанбатар хотын түүхэн товчоон” номыг Нэпко хэвлэлийн газартай хамтран бүтээж, дуусгасан. Уг ном нь нийт 320 нүүртэй бөгөөд Улаанбаатар хотын түүхийг олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарласан анхны бүтээл болсон. Агуулгын хувьд Эртний түүхт нутаг дэвсгэр, Богдын хүрээ хот, Орчин үеийн Улаанбаатар хот, Шинэ үеийн Улаанбаатар хот гэсэн 4 бүлгийн нийт 131 сэдэвтэй.<br>2.Сүхбаатар дүүргийн 60 жилийн ойд зориулсан “Сүхбаатар дүүрэг он дараалын бичиг” номыг Нэпко хэвлэлийн газартай хамтран бүтээж, дуусгав. Уг ном нь 150 нүүртэй бөгөөд Сүхбаатар дүүргийн түүхэнд холбогдох онцлох үйл явдлыг багтаасан ном.<br>-2024.12.27-нд Гандантэгчэнлин хийд дахин сэргэсний 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд “V Богдын ордон: Гандантэгчэнлин хийд” сэдвээр илтгэл, хэлэлцүүлэг; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2025.04.14-нд Сүхбаатарын дүүргийн 60 жилийн ойд зориулсан “Өнгөрсөн-одоо-ирээдүй” сэдэвт арга хэмжээнд “Сүхбаатар дүүрэг: Улаанбаатар хотын түүх, соёлын голомт” илтгэл;<br>-2025.10.08-нд “Монголын гэрэл зургийн үүсэл хөгжил-90 жил” олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Францын Алберт Канн, Стефан Пассегийн үлдээсэн өв: Улаанбаатар хотын анхны өнгөт гэрэл зураг, дүрс бичлэгт хийсэн шинжилгээ” сэдэвт илтгэл, хэлэлцүүлгийг музейн эрдэм шинжилгээний ажилтан хийв.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.5.4 | Музейн үзмэрүүдэд тодорхойлолт бичиж, үзмэрийн түүхийн судалгааг хийх, музейн сан хөмрөгт буй монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийг хөрвүүлж, орчуулна. | - | Хөрвүүлсэн үзмэрийн тоо | 20 | 32 | 2025 онд хөрвүүлэх, судлах үзмэрийн жагсаалтыг Музейн захирлын 2025.02.10-ны А/08 тушаалаар батлуулж 32 үзмэрийн судалгаа, хөрвүүлгийн ажлыг хугацаанд нь хийж дуусгав.<br>Үзмэрийн түүхийн судалгаа хийж тодорхойлолт бичин,алдаатай мэдээллүүдийг зассан 20 үзмэр:<br>1. 123.Хотод автобус явуулах тухай бичиг<br>2. 254.Олимп-80 сүрлэн наамал<br>3. 316.Түүхт Улаанбаатар<br>4. 318.БНМАУ мандтугай<br>5. 326.Улаанбаатар гобелен хивс<br>6. 338.Занабазар<br>7. 342.Хатан туул<br>8. 343.“Мэлхий хөшөө” загвар<br>9. 396.Сүхбаатар амьдарч байсан байшин<br>10. 533.12-р хороолол<br>11. 357.Анхны радио<br>12. 539.Яндангийн цуурай<br>13. 554.Субботник<br>14. 579.5-р хороолол<br>15. 584.Шинэ цирк<br>16. 587.4-р хороолол<br>17. 588. 6-р хороолол | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 18. 629.Түүхт талбай<br>19. 642.Долоон хошуу даншиг наадам<br>20. 654.Хүрээ дөрвөн уул<br>Монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийг хөрвүүлж, орчуулсан 12 үзмэр:<br>1. 116.Сүм барих судар<br>2. 117.Үнсэн самбар<br>3. 120.Хотын намын хороо байгуулах тухай бичиг<br>4. 126.Хонины булаг жүжгийн программ<br>5. 131.Алтан цох<br>6. 133.Тооцооны дэвтэр<br>7. 136.Хүний биеийн анатомийн тухай төвд бичиг<br>8. 160.Шинэ үсгийн хичээлийн дэвтэр<br>9. 161.Газар зүйн хичээлийн конспект<br>10. 162.Цэвэгжавын улс төрийн хичээлийн конспект<br>11. 168.Европ тивийн товчлол<br>12. 191.Цэвэгжавын тооны хичээлийн конспект<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.5.5 | “Богдын хүрээний түүхийг гэрэл зургаар тодруулах нь” сэдэвт судалгааг үргэлжлүүлнэ. | - | Судалгааны бичвэрийн хуудасны тоо | 30 | 30 | “Богдын хүрээний түүхийг гэрэл зургаар тодруулах нь” судалгааны хүрээнд 1874-1911 онд Их хүрээнд ирсэн 10 гадны жуулчин, судлаачдын гэрэл зургийн талаар 30 нүүр бичиж, судалгаа хийв.()<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.6 | **Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна. УБХМД-4.2.6/ /ХХИ-60-Боловсролын хүртээмж/** | | | | | | |
| 3.6.1 | “Бидний баатар хот” урт хугацааны боловсролын хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хүүхэд залуучуудыг хамруулна. | - | Хөтөлбөрийн тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 4<br>300 | 4<br>600 | “Бидний баатар хот” урт хугацааны боловсролын хөтөлбөрийн хүрээнд дараах 7 дэд хөтөлбөрийн удирдамж, төлөвлөгөөг боловсруулан музейн захирлаар батлуулж хэрэгжүүлэн ажиллав.<br>2025 онд боловсролын хөтөлбөрт нийт 9,000,000 сая төгрөг тусгагдсанаас 3,950,780 төгрөг зарцуулсан ба хөтөлбөрт зарцуулагдах зардлын үнийн судалгаа хийж, тушаалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөл боловсруулан, төсвийг батлуулан хэрэгжүүлсэн.<br>Музейн боловсролын хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн тоо:<br>2025 онд нийт **7 төрлийн** 8 дэд хөтөлбөрийг 89 удаагийн давтамжтайгаар 2,857 хүүхдэд, 69 том хүн, **нийт 2888** хүнийг боловсролын хөтөлбөрт амжилттай хамруулан ажилсан.<br>Зохион байгуулсан хөтөлбөрүүд:<br>1.“Гэр бүл эерэг орчин” боловсролын хөтөлбөр<br>2.“Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” боловсролын хөтөлбөр<br>3.“Бяцхан ертөнц” боловсролын хөтөлбөр<br>4.“Дугуйт найзтай танилцъя” боловсролын хөтөлбөр<br>5.“Соёлтой хот-Соёлтой иргэн” боловсролын хөтөлбөр<br>6.“Хог хаягдлыг ялган ангилах нь” боловсролын хөтөлбөр<br>7.“Соёл түгээе” боловсролын хөтөлбөр<br>“Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” боловсролын хөтөлбөр (Зураг 14)<br>❖ Улаанбаатар хотын музейн 2026-2030 он хүртэлх урт хугацааны боловсролын хөтөлбөрийг боловсруулан арга зүйн зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж батлуулав.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.6.2 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд музейн үзмэр болох “Өндөр Гэгээн Занабазар” баримлыг 3D загвараар жижгэрүүлсэн хэв хийлгэж, хэвд моделийг гипсээр цутган боловсролын хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн болгож хөтөлбөрийг бүтээлч хэлбэрээр зохион байгуулна. | - | Хамрагдсан иргэдийн тоо | - | 30 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хуулийн хэрэгжилтийн хүрээнд, Улаанбаатар хотын музейд хадгалагдаж буй “Өндөр Гэгээн Занабазар” баримлыг 3D загварчлал (модел) үүсгэх, мөн түүнчлэн тухайн загварын жижгэрүүлсэн хэвийг хийлгэн хүүхэд залуучуудыг соён гэгээрүүлэх, танин мэдэхүйд боловсролын хөтөлбөрөөр дамжуулан 3D хэвийг ашиглах төрөл бүрийн хэмжээтээр өөрсдийн гараар хэвэнд хийж гипсээр цутган гоёл чимэглэл, мерчентайз байдлаар түгээн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэлгэрүүлэхээр төлөвлөсөн. Тус ажлыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллагуудын харьцуулсан судалгааг хийж нийт зардлын урьдчилсан тооцоо, үнийн судалгааг гарган музейн удирдагад танилцуулан бэлэн болгосон.<br>Гэвч орон нутгийн төсвийн хэмнэлтийн бодлогоос шалтгаалан, дээрх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байсан санхүүжилтын зарцуулах эрхийг сангийн яамнаас хаасанаас болж энэхүү ажлыг хэрэгжүүлж үр дүнг гаргах боломжгүй болсон. 2026 оны төлөвлөгөөнд дахин тусгахаар төлөвлөсөн.(Зураг 22)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 50% | |
| 3.6.3 | Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Иргэд болон байгууллагуудад Улаанбаатар хотын түүх сэдвээр лекц зохион байгуулна. | - | Хамрагдсан иргэдийн тоо | 100 | 120 | Тайлант хугацаанд нийт 16 удаагийн лекц, хичээлд нийт 557 хүн хамрагдаж, хотын түүх, соёл, архитектур, хот байгуулалтыг сурталчлах ажлыг зохион байгуулав.<br>1.Гайд сургалтын төвтэй хамтран “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ” лекцийг 5 удаа уншиж, нийт 137 гайдыг хамруулж, хотын түүхийн мэдлэгийг дээшлүүлэв.<br>2.Монгол Арт галерейд “Богдын хүрээ хотыг дүрсэлсэн монгол зураг” тусгай үзэсгэлэнд зориулан эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр “1870-аад оны Их хүрээ хотын монгол зураг” лекц-35 хүнд<br>3.ШУТИС-ийн Хот төлөвлөлтийн салбарын магистрийн ангийн 12 оюутанд “Улаанбаатар хот: Хот төлөвлөлт ба түүх, соёлын дурсгал” сэдэвт лекц<br>4.МУИС-ийн Хот ба бүс нутаг төлөвлөлтийн 3-р түвшний 21 оюутанд “Улаанбаатар хотын хөгжлийн түүх” сэдвээр хичээл заав.<br>5.АВ трэйвэл ХХК-ийн гайдын сургалтад хоёр удаа “Улаанбаатар хотын түүхэн хөгжил” сэдэвт лекц-46 хүнд. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6.Улаанбаатар трэйвэл экспо 2025 арга хэмжээнд “Гэрэл зураг дахь Улаанбаатар: Хот ба хүмүүс” сэдэвт лекц -57 хүнд<br>7.Монгол Коосен технологийн коллежийн Барилгын инженерийн ангийн 32 оюутанд “Улаанбаатар хотын барилга архитектурын түүх” сэдвээр лекц уншив.<br>8.“Оюутан цагдаа-2025” сургалтын арга хэмжээнд “Улаанбаатар хотын түүх, соёл ба гудамж, таних тэмдэг” сэдэвт лекц-45 оюутанд<br>9.Хөгжлийн банкны 7 ажилтанд “Улаанбаатар хотын хөгжлийн түүх” сэдвээр лекц уншив.<br>10.Залуу хот судлаач хөтөлбөрт хамрагдсан 15 сурагчдад “Улаанбаатар хот: түүх, хот байгуулалт, архитектур, соёлын өв” сэдвээр лекц уншив.<br>11.Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсээс зохион байгуулсан “Бид архивчид” сургалтад хамрагдаж буй дүүргийн 150 архивчдад “Улаанбаатар хотын түүх, соёлын голомт” сэдвээр лекц уншив.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.6.4 | Музейгээс бэлтгэн гаргасан “Марчаахай”, “Хотын түүхийг хоёр минутад” 3 төрлийн контентод сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгай дохионы хэл рүү хөрвүүлсэн тайлбар нэмж оруулан шинэчилнэ. | - | Хөрвүүлсэн контентын тоо | - | 3 | Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан Улаанбаатар хотын музейгээс бэлтгэн гаргасан “Хотын түүхийг хоёр минутад”, “Марчаахай” контентуудад тусгай дохионы хэлийг нэмж шинэчлэн гаргав. Тус ажилд зарцуулагдах зардлын үнийн судалгааг гаргаж, тушаалын төслийг боловсруулан, төсвийг батлуулан “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбоо”-той хамтран гүйцэтгэв. Ажлын гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 28-нд ажлыг гүйцэтгэж дуусгасан. 2025 оны 04 дүгээр сарын 29 нд ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээн авч олны хүртээл болгов.<br>Дохионы хэлний хөрвүүлэгтэй контентууд<br>**1.“Хотын түүхийг хоёр минутад”** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Хотын үүсэл контент 1<br>-Түүхэн нэрүүд контент 2<br>-Цогтбадамжавын байшин контент 3<br>**2.“Марчаахай”**<br>-Өргөөгөөс нийслэл хүрээ 1639-1911 контент 4<br>-Марчаахай нийслэл хүрээнд контент 5<br>-Социалист Улаанбаатар контент 6<br>(Зураг 23)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.6.5 | Музейн цахим хуудас, веб сайтаар дамжуулан иргэдэд хотын түүхийн талаар танин мэдэхүйн мэдлэг олгох цуврал мэдээллүүдийг бичлэгээр хүргэнэ. | - | Бичлэгийн тоо | - | 10 | Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгалуудын товч түүх, барилгын архитектурыг харуулсан **12** цуврал бичлэг болон “Соёлын бүтээлч сар-2025” аяны хүрээнд Өндөр Гэгээн Занабазарын мэлмий нээсний 390 жилийн ойд зориулан музейд хадгалагдаж буй “Занабазар” баримал, “Очирдарь” зээгт наамлын талаарх бичлэгийг монтажлан засварлаж музейн мэдээллийн цахим сувгууд болох ERP сүлжээ, инстаграм мөн facebook хаягуудад тус тус байршуулан олон нийтийн хүртээл болгосон.<br>Дээрх бичлэгийн хүрээнд нийт **104,746** хүний хандалт авсан. Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд болон үзмэрийн талаарх бичлэгийг олон нийтийн сүлжээнд оруулснаар хотын ой санамж болсон үл хөдлөх дурсгалууд, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд хүртээмжтэй байдлыг бий болгох, хотын дүр төрхийг хамгаалах, байгууллагын цахим хандалтыг өсгөх зэрэг олон талын эерэг үр дүнтэй байсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.7 | **Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ. /УБХМД-4.2.7/** | | | | | | |
| 3.7.1 | “Улаанбаатарын мэдээ” сонины эмхэтгэлийн 3 дугаар ботийг хэвлүүлж, олны хүртээл болгоно. | - | Хэвлүүлсэн номын тоо | 100 | 100 | 2025.02.23-нд Мэдээлэл судалгааны цахим хүрээлэн ТББ-тай №25/05-01 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, сонинд хэвлэгдсэн хотын түүхтэй холбогдох 1,000 нүүр хурлын | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илтгэл, мэдээг шивүүлэхээр гэрээнд тусгаснаас 500 нүүрийг цахим хэлбэрт шилжүүлж, хүлээлгэн өгсөн. Үлдсэн 500 нүүрийг шивж хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байх хугацаанд Засгийн газраас төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, Сангийн яамнаас музейн төсөв зарцуулах эрхийг хаасан тул цахим хэлбэрт шилжүүлсэн баримтыг хүлээн авах, цаашлаад баримтын эмхэтгэлийг эхийг бэлтгэх, хэвлүүлэх санхүүжилтгүй болж хойшлогдсон.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 30% | |
| 3.7.2 | Музейн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдэд түүх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоомыг дахин хэвлүүлж хүүхэд залуусын хүртээл болгоно. | - | Хэвлүүлсэн тоо | - | 50 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар музейгээс бэлтгэн гаргасан “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоомыг дахин хэвлэлтэд өгөх ажлыг хийж гүйцэтгэв. Тус ажилд зарцуулагдах зардлын үнийн судалгааг гаргаж, тушаалын төслийг боловсруулан төсвийг батлуулан ажилласан. “Сэлэнгэ прэсс” ХХК-тай хамтран гүйцэтгэж, ажлын гэрээг 2025 оны 07 дугаар сарын 04-ны өдөр байгуулж 2025 оны 07 дугаар сарын 07-нд ажлыг хийж дуусгасан. 2025 оны 07 дугаар сарын 08-нд ажил хүлээлцэх акт үйлдэн, хэвлэгдэн гарсан **100 ширхэг** “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоомыг хүлээн авсан. Хөлөгт тоглоомын туслах хэрэглэгдэхүүн болох 400 ширхэг хүүг дотоод нөөц бололцоогоо ашиглан хэвэнд гипсээр цутган бэлтгэн гаргаж, хатаах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн туслах хэрэглэгдэхүүн болох шоо, зиптэй уут, том уут зэргийг туслах материал худалдах дэлгүүрээс авсан. Хөлөгт тоглоомд туслах хэрэглэгдэхүүнийг хийж ууталж савлан няравт тоо ёсоор нь хүлээлгэн өгсөн. (Зураг 24)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.8 | **Соёлын биет өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд холбогдох мэдээллийг дамжуулна. /УБХМД-4.2.8/** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.8.1 | Музейн үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2024 оны үйл ажиллагаанд үүссэн баримт бичгийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийнэ. | - | Бүрдүүлэлт хийсэн баримтын тоо | 5 | 5 | Үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2024 онд үүссэн баримт бичгүүдийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 7 төрлийн баримтыг архивлан бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийлээ. Үүнд:<br>1.Сэргээн засварлуулсан үзмэрийн тайлан<br>2.Бүртгэл мэдээллийн сангийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ<br>3.Сан хөмрөгчийн ажил хүлээлцсэн тухай баримт<br>4.2024 онд музейд санал болгосон эд өлгийн зүйлийн холбогдолтой баримт<br>5.Музейд 2024 онд шинээр авсан үзмэрийн холбогдох баримт бичиг<br>6.Музейгээс үзмэр, эд өлгийн зүйл гаргасан тухай хөдөлгөөний акт<br>7.Музей дотор үзмэр, эд өлгийн зүйл хүлээлцсэн акт<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.8.2 | Музейн бүртгэл мэдээллийн сангийн тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, Соёлын Өвийн Үндэсний төвд хүргүүлнэ. | - | Гаргасан тайлангийн тоо | 1 | 1 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийн сангийн 2025 оны тайланг ТСХДЗ-2.1, ТСХДЗ-2.2 маягтын дагуу гарган Соёлын Өвийн Үндэсний төвд хүргүүлсэн.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.9 | **Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал, хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана. /УБХМД-4.2.8/** | | | | | | |
| 3.9.1 | Өөрийн цахим хуудасд санхүү, аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь, музейн чиг үүргийн хүрээнд зохион байгуулсан ажил, өргөдөл гомдол, нээлттэй ажлын байрны мэдээллийг цаг тухайд нь ил тод байршуулна. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Музейн үндсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө, биелэлт, хаяг, холбоо барих мэдээлэл, санхүүгийн аудитын дүгнэлт, статистик мэдээ, хүний нөөцийн талаарх холбогдох мэдээлэл болон байгууллагад хамаарах бүхий л мэдээллийг цахим хуудсаар дамжуулан 1,2,3-р улирал тутамд 100 хувийн гүйцэтгэлтэйгээр www.shilen.gov.mn, www.ubmuseum.mn | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуудсанд ил тод байршуулан мэдээлсэн. Нийт 68 мэдээ, мэдээлэл оруулсан байна. Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.06.30 Биелэлтийн хувь: 100% | |
| 3.9.2 | Музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг байгууллагын олон нийтийн цахим сувгуудаар /инстаграм, фейсбүүк/ дамжуулан олон нийтэд хүргэнэ. | - | Хандалтын тоо | 5,000 | 6,000 | Улаанбаатар хотын музейн цахим хуудас, инстаграм болон фэйсбүүк хаягт музейн үйл ажиллагаа, боловсролын ажил болон тэмдэглэлт өдрүүдтэй холбоотой 176 мэдээ, нийтлэлийг түгээж 298,131 үзэгчийн хандалт авсан. www.facebook.com/Ulaanbaatarcitymuseum www.ubmuseum.mn, https://erp.ulaanbaatar.mn/#/home www.instagram.com/Ulaanbaatarcitymuseum | 100 |
| 3.9.3 | Музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэн, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана. | - | Төвлөрүүлсэн орлогын хэмжээ | 3,780 | 3,780 | 2025 оны 12 сарын 03-ны байдлаар үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,780.0 мянган төгрөг, гүйцэтгэл 3,163.0 мянган төгрөг. Төлөвлөгөө 83.67% биелэсэн үзүүлэлттэй байна. Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02 Биелэлтийн хувь: 83,67% | 83,67 |
| **Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт -** Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгоход чиглэсэн зорилт. /Үүнд: албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад шууд үзүүлж байгаа бүртгэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, зөвшөөрөл/ | | | | | | | |
| 4.1 | Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэнэ. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг edoc системийн “Өргөдөл гомдол” системд албан хаагчдаас ирүүлсэн 6 өргөдлийг бүртгэн, шийдвэрлэж холбогдох дээд байгууллага болох “Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр хянуулав. Шийдвэрлэлтийн хугацаа 2 хоног 10 цаг 19 минут байна. (хавсралт 4) Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.06.30 Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 4.2 | Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг хийж, | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 2 | 2 | Тайлант хугацаанд "Улаанбаатар хотын музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа"-нд нийт **114** хүнээс судалгааг авч түүний мөрөөр авах арга хэмжээг боловсруулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. | | | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог<br>нэмэгдүүлэх зорилгоор дараах ажил зохион байгуулагдсан.<br>1.Марчаахай (3 бичлэг), Хотын түүхийг хоёр минутад (3 бичлэг) контентуудад дохионы хэлийг нэмж шинэчилж, Марчаахай контентын 3 ангийг музейн мэдээллийн цахим сувгууд болох ERP сүлжээ, инстаграм мөн facebook хаягуудад тус тус байршуулан нийт **13,684** хүний хандалт авсан.<br>Холбогдох линк:<br>https://www.facebook.com/share/v/1ACTY2Uwta/<br>https://www.facebook.com/share/v/17YpfQVNCW/<br>https://www.facebook.com/share/v/1Jx8ZVPeqw/<br>2. 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/256 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр НХААГ/2025010163 дугаартай тендер зарлаж Гурвангис ХХК-ийг сонгон шалгаруулсан болно. Тус байгууллага нь музейн 2, 3-р танхим, үүдний болон бие засах өрөөг засварлан, гаднах шатыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартын дагуу хийж, хүртээмжтэй орчныг бий болгон ажилласан.<br>(Зураг 6)<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой захирлын шийдвэр, холбогдох мэдээллийг ажлын 3 өдрийн | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой Музейн захирлын гурван А тушаалыг ажлын 3 өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn, ubmuseum.mn хуудаст байршуулсан.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.06.30<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулна | | | | | | |
| 4.4 | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах. | - | Байршуулсан мэдээллийн тоо | 1 | 1 | 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж гарган батлуулж, шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.<br>Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.06.30<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5 | Шилэн дансны цахим системд байршуулах санхүүгийн мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулна. | - | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулсан. Нийт мэдээллийн тоо 156, үүнээс хугацаандаа 155, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээ, мэдээлэл байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 сарын 19-ны өдрийн А/341 дугаар захирамжаар томилогдсон нийслэлийн Дотоод аудитын ажлыг хэсэг байгууллагын 2024-2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, шилэн дансны дотоод аудитын шалгалт хийгдэж, алдаа дутагдал, зөрчил гараагүй.<br>Эхлэх дууссан огноо: 2025.01.02-2025.12.02<br>Биелэлтийн хувь: 99% | 99 |

**ДҮГНЭЛТ : Нийт 56 арга хэмжээ хэрэгжүүлснээс 50 арга хэмжээ нь 100 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ нь 99 хувийн биелэлтэй, 2 арга хэмжээ 90 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 83,67 хувийн биелэлттэй. 1 арга хэмжээ 80 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 30 хувийн биелэлттэй байгаа ба нийт үзүүлэлтээр 98.39 хувийн биелэлттэй байна.**

| № | Зорилт, арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Биелэлт хувь |
|---|---|---|---|
| 1 | Бодлогын баримт бичиг | 1 | 100 |
| 2 | Хуулиар хүлээсэн чиг үүрэг | 20 | 99 |
| 3 | Дүрмээр хүлээсэн чиг үүрэг | 30 | 94.79 |
| 4 | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | 5 | 99.8 |
| **5** | **Нийт хэрэгжүүлсан арга хэмжээ** | **56** | **98,39** |

**52 арга хэмжээ-90--100%-**"бүрэн хэрэгжсэн" - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь 50 арга хэмжээ 90 хувийн 2 арга хэмжээ

**3 арга хэмжээ-50-90% -**"хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа гэсэн 83,67 хувийн 1 арга хэмжээ, 80 хувийн 1 арга хэмжээ, 50 хувийн 1 арга хэмжээ

**1 арга хэмжээ-10-50% -**"хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь гэсэн 30 хувийн 1 арга хэмжээний үзүүлэлтэй тус тус дүгнэгдэж байна.

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ П.ДАВААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
МЕНЕЖЕР Б.НАРАНГЭРЭЛ

Засварын ажилтай холбоотой зураг






## 1. Боловсролын хөтөлбөрийн зурагнууд






## 2. Үзэсгэлэнгийн арга хэмжээний зурагнууд















### 3. Лекц





### 4. Цахим орчинд

- Соёлтой иргэн байх бяцхан зөвлөмжүүдийг харуулсан постер зургийг музейн цахим хаягуудад байршуулсан. Сошиал орчинд цахим хандалтын тоо **3997** байна.

- “Хотын түүхийг хоёр минутад”, “Марчаахай” контентуудад тусгай дохионы хэлийг нэмж, шинэчлэн гаргах ажлыг “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын  холбоо” ТББ-тай хамтран хийсэн.  Нийт хандалтын тоо **9687** байна.






**5. Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалт**



